



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/235

Улаанбаатар хот

Захирамжийн холбогдох заалт болон,
газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Базарын Дагийсүрэн, Баясахын Сугар нар нь Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо, Майхан толгойд өөрийн эзэмшлийн 1501213401 нэгж талбар бүхий 732 м.кв газар, 1501213295 нэгж талбарын дугаар бүхий 732 м.кв газруудын газар эзэмших эрхээс татгалзах хүсэлт ирүүлснийг үндэслэн газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2.Энэ захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2023 оны А/232 дугаар захирамжийн иргэн Базарын Дагийсүрэн, Баясахын Сугар нарт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ж.Тамир)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010681